

**ЦАНХИЙН БАРУУН УУРХАЙН ХӨРС ХУУЛАЛТ, НҮҮРС ОЛБОРЛОЛТЫН  
АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР**



**Агуулга**

1. ХИЙГДЭХ АЖИЛ .....	1
1.1. Хөрс хуулалт: .....	1
1.2. Нүүрс олборлолт: .....	2
1.3. Инженерийн ажил .....	3
1.4. Хяналт, удирдлагын систем .....	3
1.5. Зам талбай засах, услах: .....	4
1.6. Уурхайн ус таталт, шүүрүүлэлт: .....	4
1.7. Хөрсний овоолго: .....	5
1.8. Нүүрсний овоолго: .....	5
1.9. Байгаль орчин, усны бодлого, орчны хамгаалал, нөхөн сэргээлт: .....	6
1.10. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй: .....	6
1.11. Уулын ажлын гүйцэтгэх үнэлгээ .....	7
1.12. Ажлын даалгаврын хавсралт .....	7
2. ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА .....	8
2.1. Ерөнхий: .....	8
2.2. Хүн хүч: .....	8
2.3. Уулын ажилд ашиглагдах Техник хэрэгсэл, машин механизм: .....	9
2.4. Дэд бүтэц, барилга, байгууламж: .....	10
3. БУСАД ШААРДЛАГА .....	11
4. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУВААРЬ .....	13

## **ЦАНХИЙН БАРУУН УУРХАЙН ХӨРС ХУУЛАЛТ, НҮҮРС ОЛБОРЛОЛТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР**

Гүйцэтгэгч нь батлагдсан зураг төсөл, ажлын төлөвлөгөө, захиалагч талын өгсөн чиглэл, зааварчилгаа болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны стандарт, дүрэм, журам, бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгой ордын Цанхийн баруун уурхайд хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажил гүйцэтгэнэ.

### **1. ХИЙГДЭХ АЖИЛ**

#### **1.1. Хөрс хуулалт:**

Уурхайн хөрс ухаж ачих, шимт хөрс хуулах, ачих, тээвэрлэх, байршуулах, овоолгын техникийн нөхөн сэргээлт хийж хэлбэршүүлэх, нүүрсний тааз цэвэрлэх, ажлын болон ажлын бус ханын цэвэрлэгээ хийх, үерийн уснаас уурхайг хамгаалах далан, суваг, шуудуу байгуулах, уурхайн шүүрлийн усыг хуримтлуулах, зайлуулах, усан сан байгуулах, зумпф ухах, ус шүүрүүлэлт хийх, талбайн усалгаа, гэрэлтүүлэг хийх, зам засах, нүүрсний овоолгын талбай бэлтгэх, дэвсэлт хийх, мөргөцгийн хажуугийн тогтворжилтын хяналт, хийх гэх мэт уурхайн олборлолт, уулын ажлын өрнөлттэй холбоотой бүхий л ажлуудыг хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж гүйцэтгэнэ.

1.1.1. Захиалагчийн баталсан уулын ажлын төлөвлөгөө, паспорт, журам, горим, зааврыг мөрдлөг болгон уулын ажлыг гүйцэтгэнэ.

1.1.2. Уулын ажлын урьдчилсан төлөвлөгөөг захиалагч талаас сар бүр гаргана. Тухайн сарын төлөвлөгөөг сар эхлэхэд захиалагч тал боловсруулж баталсан байна.

1.1.3. Гүйцэтгэгч тухайн сард ажиллах үндсэн тоног төхөөрөмжийн техникийн бэлэн байдлын мэдээллийг өмнөх сарын 25-аас өмнө, 7 хоногт ажиллах үндсэн тоног төхөөрөмжийн бэлэн байдлын мэдээллийг өмнөх 7 хоногийн Бямба гарагаас өмнө Захиалагчийн төлөвлөлтийн нэгжид хүргүүлнэ

1.1.4. Уурхайн болон овоолго, мөргөцгийн хажуугийн тогтворжилтод байнгын хяналт, судалгаа хийнэ. Нуралт, гулсалт үүссэн тохиолдолд тухайн хэсгийг аюулгүй болгох, нурсан материалыг шилжүүлэх арга хэмжээ авна. Мөргөцгийн нуралт гулсалтаас шалтгаалах асуудлыг гүйцэтгэгч тал бүрэн хариуцна. Хяналт хийх мэргэжлийн багаж, тоног төхөөрөмжийн хангалт, бэлэн байдлыг хангаж ажиллана.

1.1.5. Чулуулгийн тогтворжилтоос нь хамааруулан уурхайн ажлын болон ажлын бус догол, мөргөцгийг 35-55 градусаар болон уурхайн загварчлалын дагуу налуулж экскаватороор хананы цэвэрлэгээ хийнэ.

1.1.6. Уурхайн бүсэд хөрс, нүүрс тээврийн зам, талбайг засах, өргөтгөх, шинээр барих, сайжруулах, услах, арчлах ажлуудыг Захиалагчийн гаргасан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэгч өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ.

1.1.7. Овоолго байршуулах талбайгаас шимт хөрс хуулах ажлыг бүтээлийн бус инженерийн ажилд тооцох бөгөөд гүйцэтгэгч өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ.

1.1.8. Батлагдсан журам, горим, заавар, зураг төсөл, төлөвлөгөөний дагуу үндсэн хөрс, элс хайрганы холимог хөрс (шимэрхэг), шимт хөрсний овоолгууд үүсгэх, хэлбэржүүлэх, зам талбай тэгшлэх, техникийн нөхөн сэргээлт хийх зэрэг ажлуудыг гүйцэтгэнэ.

1.1.9. Уурхайн догол, мөргөцгийн улыг төлөвлөгдсөн загварчлалын өндөржилтийн түвшингөөс дээш, доош 20 см-ийн хэлбэлзэлтэй байлгаж болно. Мөргөцгийн улыг түвшин хэмжигч /Laser level/ ашиглаж хянах. Уурхайд ухалт ачилт хийх экскаватор, ачигчийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, ул талбай тэгшлэх туслах техник бульдозеруудыг

тогтмол ажиллуулна.

1.1.10. Уурхайн хөрсийг Хөрсний 2 болон 3-р овоолго руу тээвэрлэж байршуулна.

1.1.11. Хөрсний овоолгын хаагдаж байгаа доголыг журам, стандартын дагуу налуулж техникийн нөхөн сэргээлт хийнэ.

1.1.12. Өрөмдлөгийн талбайг паспортын дагуу бэлтгэн хүлээлгэж өгөх бөгөөд уурхайн хөрсний мөргөцгөөс ачилт хийхдээ дараагийн өрөмдлөг орох талбайн улыг өрөм ороход саадгүй байхаар талбайг бэлдэнэ.

1.1.13. Захиалагч нь уурхайн бүхий л талбай, хэсгүүдэд өөрийн эзэмшлийн тоног төхөөрөмжөөр уулын ажлыг төлөвлөж, гүйцэтгэж болно.

1.1.14. Хаагдсан шимт хөрсний овоолгыг хадгалалтад бэлтгэж журамд заасны дагуу хэлбэршүүлж, хүлээлгэн өгнө.

1.1.15. Уурхайн бусад хэсэгт уулын ажил гүйцэтгэж буй гэрээт олборлогч компаниудын техникийн бэлэн байдал буурах, уурхайн технологийг алдагдуулахгүй байх шаардлагаар Захиалагчийн саналаар урьдчилан мэдэгдэн уурхайн бусад хэсэгт Гүйцэтгэгчийн техник, тоног төхөөрөмжийг гэрээнд заах үнээр хөрвүүлэн ажиллуулж болно.

## **1.2. Нүүрс олборлолт:**

Нүүрсийг мөргөцгөөс ангилан ухаж ачих, ялгах, тээвэрлэх, байршуулах, нүүрсний ул, тааз цэвэрлэх, талбайн усалгаа, гэрэлтүүлэг хийх, зам засах, нүүрсний овоолгын талбай бэлтгэх, дэвсэлт хийх, мөргөцгийн хажуугийн тогтворжилтын хяналт хийх гэх мэт уурхайн нүүрс олборлолттой холбоотой бүхий л ажлуудыг хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж гүйцэтгэнэ.

1.2.1. Захиалагчийн баталсан уулын ажлын төлөвлөгөө, паспорт, журам, горим, зааврыг мөрдлөг болгон уулын ажлыг гүйцэтгэнэ.

1.2.2. Уулын ажлын урьдчилсан төлөвлөгөөг захиалагч талаас сар бүр гаргана. Тухайн сарын төлөвлөгөөг сар эхлэхэд захиалагч тал боловсруулж баталсан байна.

1.2.3. Нүүрсний бүхий л мөргөцөгт тухайн нүүрсний давхраасын тогтцод уялдсан техник, тоног төхөөрөмжийг оновчтой сонгож ухалт, ачилт болон ангилан ялгалт хийж хаягдал, бохирдлыг хамгийн бага байлгахгаар олборлолтын ажлыг зохион байгуулна.

1.2.4. Нүүрс олборлох болон хөрс хуулах үедээ нүүрсийг бохирдуулсан, хаясан тохиолдолд захиалагч акт үйлдэж, тухайн жилийн хөрс хуулалтын илтгэлцүүрийн өссөн дүнгээр тооцон хуулсан хөрсний хэмжээг гаргаж, хаясан нүүрсийг борлуулах үнээр тооцон уулын ажлын гүйцэтгэлээс хасаж тооцно.

1.2.5. Уурхайн нүүрсний мөргөцгөөс олборлох бүхэллэгийн хэмжээг Захиалагчийн шаардлагад нийцүүлж бага байхаар олборлоно.

1.2.6. Нүүрсний овоолгод овор хэтэрсэн нүүрс гарах тохиолдолд буталж, жижиглэнэ.

1.2.7. Уурхайн нүүрсний мөргөцөг болон нүүрсний овоолгоос чанарын дээж авах ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг хугацаа алдалгүй ажиллуулна.

1.2.8. Нүүрсний овоолгод халалт, уугилт болон гал гарсан үед галын голомтыг тараан хөргөх, таслан ачих, тусгаарлах, тээвэрлэн зайлуулах, хучих ажлыг хийж гүйцэтгэнэ. Тусгаарлаж хөргөсөн нүүрсийг чанараас нь хамааруулан нүүрсний овоолго болон хөрсний овоолгод шилжүүлэх ажлыг гүйцэтгэнэ.

1.2.9. Ажлын талбай дахь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах үүднээс ачилт хийж буй хэсгийн тээврийн зам, ажлын бүс, овоолго бүрд, ажлын талбайн гэрэлтүүлгийг

байрлуулан ажиллана.

1.2.10. Нүүрсний овоолгын болон нүүрсний агуулахын зам, нүүрсний овоолгын ул, талбай, нүүрсний овоолго хоорондын зам, худалдааны тээврийн машины зогсоолын зам, талбайг засах, өргөтгөх, сайжруулах, услах, арчлах ажлуудыг захиалагчийн гаргасан төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэнэ.

1.2.11. Удаан хугацаагаар хадгалагдах нүүрсний овоолгыг халалт уугилтаас хамгаалах зорилготой хэлбэршүүлж налуулна.

1.2.12. Нүүрсний овоолгод бохирдолттой нүүрс, хөрс буулгасан тохиолдолд шаардлагатай шилжүүлэг, цэвэрлэгээг цаг алдалгүй тогтмол хийнэ.

1.2.13. Захиалагчийн шийдвэрээр олборлосон нүүрсийг чанараар нь ангилан овоолго үүсгэх ба нүүрсний овоолгуудад чанарын холилт хийнэ.

1.2.14. Нүүрсний агуулах дахь өндөр тоосжилттой болон эрчим хүчний нүүрсийг хамгаалж бүрхүүл үүсгэх, хучиж хамгаалах ажлыг Захиалагчтай хамтран хийж гүйцэтгэнэ.

1.2.15. Батлагдсан журам, зураг төсөл, төлөвлөгөөний дагуу нүүрсний овоолгууд үүсгэх, хэлбэржүүлэх, зам талбай тэгшлэх, ачилтын тавцан шинээр үүсгэх ажлуудыг гүйцэтгэнэ.

1.2.16. Төмөр замын ачилтын тойргийн ачиж буулгах төвд технологи болон паспортын дагуу нүүрсийг чанараар ангилан буулгаж, овоолго үүсгэнэ.

1.2.17. Нүүрсний овоолго, агуулахын суурийн өргөтгөл болон нүүрсний агуулахын зам, нүүрсний овоолгын ул, талбай, нүүрсний овоолго хоорондын зам, хяналтын пүү, орох, гарах пүүний зам, худалдааны тээврийн машины зогсоолын зам, талбайг засах, өргөтгөх, сайжруулах, услах, арчлах ажлуудыг захиалагчийн гаргасан төлөвлөгөөний дагуу өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ.

1.2.18. Захиалагч нь уурхайн бүхий л талбай, хэсгүүдэд өөрийн эзэмшлийн тоног төхөөрөмжөөр уулын ажлыг төлөвлөж, гүйцэтгэж болно.

1.2.19. Нүүрсний хаягдал, бохирдлыг бууруулах, чанарыг дундажлах зорилгоор Захиалагчийн төлөвлөгөөний дагуу нүүрсний агуулахын талбайд цагт 700 тонноос багагүй нүүрс бутлах хүчин чадал бүхий автомат удирдлагын системтэй, хөдөлгөөнт бутлуурыг овоолго үүсгэгч болон бусад бүрдлийн хамт өөрийн зардлаар гэрээ байгуулснаас хойш 3 сарын дотор суурилуулан, ашиглалтад оруулж, гэрээний хугацаа дуусмагц Захиалагчид үнэ төлбөргүйгээр шилжүүлж өгнө.

1.2.20. Гэрээний хугацаанд бутлуурын засвар, үйлчилгээ, сэлбэг хэрэгсэл, ашиглалтын зардал, ажиллах хүч болон найдвартай ажиллагааг бүрэн хариуцна.

### **1.3. Инженерийн ажил**

Уурхайд шинээр технологийн замын дэвсэлт хийх, нүүрсний агуулахын талбайг өргөтгөх, нүүрс тээврийн зам болон уурхайн маршрутын зам засах, овоолгын техникийн нөхөн сэргээлт хийж хэлбэршүүлэх, үерийн уснаас уурхайг хамгаалах далан, суваг, шуудуу байгуулах, уурхайн шүүрлийн болон гадаргын усыг хуримтлуулах усан сан байгуулах, зумпф ухах, дэвсэлт хийх гэх мэт уурхайн туслах ажлуудыг хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж гүйцэтгэнэ.

1.3.1. Гүйцэтгэгчийн хүсэлтийн дагуу хийгдэх засварын талбай, захиргааны барилга байшин, шатахуун түгээх станц болон бусад өөрсдийн үйл ажиллагаанд шаардлагатай бүтээн байгуулалтын ажлууд нь уулын ажлын гүйцэтгэлд тооцохгүй.

### **1.4. Хяналт, удирдлагын систем**

1.4.1. Цанхийн баруун уурхайн уулын ажлын технологийн удирдлагыг боловсронгуй болгох, уурхайн хяналт, нэгдсэн системийг Захиалагч нэвтрүүлж байгаатай холбоотойгоор Гүйцэтгэгч нь дэмжиж, хамтран ажиллах бөгөөд Захиалагчийн төлөвлөгөөний дагуу үе шаттайгаар үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ.

1.4.2. Гүйцэтгэгч нь уурхайн бүсэд ажиллах өөрийн эзэмшлийн машин техникт Захиалагчийн техникийн шаардлагад нийцсэн, холбогдон ажиллах боломжтой гар болон суурин станцаар ажил эхлэх үед бүрэн тоноглогдсон байна.

### **1.5. Зам талбай засах, услах:**

Уурхайн бүсийн хил доторх хөрс, нүүрс тээврийн зам, талбайг засах, өргөтгөх, шинээр барих, сайжруулах, услах, арчлах ажлуудыг захиалагчийн гаргасан төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэнэ.

1.5.1. Дотоод тээврийн налуу (траншейн зам) зам болон хөрсний овоолгын налуу зам, технологийн авто тээврийн замуудад хайрга, шавар, дайрга дэвсэнэ. Захиалагчийн олборлосон хайрга, дайрга, шаврыг тэргүүн ээлжид авч ашиглах бөгөөд төлбөрийг зах зээлийн ханшаар тохиролцоно.

1.5.2. 4 улирлын турш усалгаа хийж болохгүй үед тоос дарах дэвшилтэд технологи ашиглан (химийн бодис ашиглах гэх мэт) улирлын болон цаг агаарын саатлаас шалтгаалж гардаг сул зогсолтыг багасгах, Хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайжруулах нөхцөл бололцоог бий болгож ажиллана.

1.5.3. Усны зарцуулалтыг багасгах чиглэлээр олон улсад нэвтэрсэн, туршигдсан технологийг нэвтрүүлж, үр дүн гаргаж ажиллана. Уг ажлыг гэрээ байгуулснаас хойш Захиалагчийн боловсруулсан төлөвлөгөөт хуваарийн дагуу гүйцэтгэнэ.

1.5.4. Захиалагчаас гаргасан төлөвлөгөө, зураг төслийн хүрээнд нүүрсний агуулахын болон бусад зам талбайд өргөтгөл хийх, шинээр барих, агуулахын талбайн уланд нүүрс дэвсэх ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

1.5.5. Зам талбайг засах, шинээр тавих шаардлагаар захиалагчийн хамгаалалтын хашааг шилжүүлэх шаардлага үүссэн нөхцөлд гүйцэтгэгч нь өөрийн зардлаар үйл ажиллагаанд хамаарах хэсгийг шилжүүлэн захиалагчид хүлээлгэж өгнө.

1.5.6. Уурхайн гаднах буюу маршрутын замыг захиалагчийн гаргаж өгсөн хуваарийн дагуу зам арчилгааны ажил хийж гүйцэтгэнэ.

### **1.6. Уурхайн ус таталт, шүүрүүлэлт:**

1.6.1. Уурхайн ухаш, бусад байгууламжуудыг гадаргын болон гэнэтийн үерийн уснаас хамгаалах далан, суваг, шуудуу байгуулах, үерийн усны урсах голдирол, чиглэлийг өөрчлөх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

1.6.2. Уурхайн мөргөцөгт шүүрч орох усыг уурхайн хамгийн доод түвшингээс доош байлгаж шүүрүүлэлт, ус таталт хийнэ.

1.6.3. Уурхайн дотоод шүүрлийн болон гадаргуугийн хур тунадас, үерийн усыг шийдвэрлэх арга хэмжээг инженерийн ажлаар тооцон ажиллана.

1.6.4. Уурхайн орчинд гадаргын усыг хуримтлуулан ашиглах инженерийн байгууламжийн ажлыг захиалагчийн гаргасан төлөвлөгөөний дагуу хамтран ажиллаж гүйцэтгэнэ.

1.6.5. Уурхайн зам талбай болон мод зүлэг усалгаанд саарал буюу цэвэрлэх байгууламжаас гарсан усыг холбогдох стандарт, мэргэжлийн байгууллагаас гаргасан дүрэм, журмын дагуу ашиглана. Хэрэгжилтийг сар бүрийн гүйцэтгэлийн тайланд тусгаж захиалагчаар батлуулна.

1.6.6. Гүйцэтгэгч нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд шаардлагатай 2-с доошгүй, бүс нутгийн ундны эх үүсвэрийн зориулалтаар 1-с доошгүй усны эх үүсвэрийг өөрийн зардлаар олж тогтоон, бүрэн тоноглож, ашиглалтад оруулна.

### **1.7. Хөрсний овоолго:**

1.7.1. Овоолго байршуулах талбайгаас шимт хөрс хуулах ажлыг бүтээлийн бус инженерийн ажилд тооцно

1.7.2. Уурхайн хөрсийг Хөрсний 2-р болон 3-р овоолго руу тээвэрлэж байршуулна. Шаардлагатай тохиолдолд захиалагчийн заасан байршилд хөрс тээвэрлэж буулгана.

1.7.3. Батлагдсан журам, горим, заавар, зураг төсөл, төлөвлөгөөний дагуу үндсэн хөрс, элс хайрганы холимог хөрс (шимэрхэг), шимт хөрсний овоолгууд үүсгэх, хэлбэржүүлэх, зам талбай тэгшлэх, техникийн нөхөн сэргээлт хийх зэрэг ажлуудыг гүйцэтгэнэ

1.7.4. Хөрсний овоолгын хаагдаж байгаа доголдуудыг хэлбэршүүлж, техникийн нөхөн сэргээлт хийнэ.

1.7.5. Хаагдсан шимт хөрсний овоолгыг хадгалалтад бэлтгэж журамд заасны дагуу хэлбэршүүлж, хүлээлгэн өгнө.

### **1.8. Нүүрсний овоолго:**

1.8.1. Нүүрсний овоолгод овор хэтэрсэн нүүрс гарах тохиолдолд буталж, жижиглэнэ.

1.8.2. Уурхайн нүүрсний мөргөцөг болон нүүрсний овоолгоос чанарын дээж авах ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг хугацаа алдалгүй ажиллуулна.

1.8.3. Нүүрсний овоолгод халалт, уугилт болон гал гарсан үед галын голомтыг тараан хөргөх, таслан ачих, тусгаарлах, тээвэрлэн зайлуулах, хучих ажлыг хийж гүйцэтгэнэ. Тусгаарлаж хөргөсөн нүүрсийг чанараас нь хамааруулан нүүрсний овоолго болон хөрсний овоолгод шилжүүлэх ажлыг гүйцэтгэнэ.

1.8.4. Нүүрсний овоолгын болон нүүрсний агуулахын зам, нүүрсний овоолгын ул, талбай, нүүрсний овоолго хоорондын зам, худалдааны тээврийн машины зогсоолын зам, талбайг засах, өргөтгөх, сайжруулах, услах, арчлах ажлуудыг захиалагчийн гаргасан төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэнэ.

1.8.5. Удаан хугацаагаар хадгалагдах нүүрсний овоолгыг халалт уугилтаас хамгаалах зорилготой хэлбэршүүлж налуулна.

1.8.6. Батлагдсан журам, зураг төсөл, төлөвлөгөөний дагуу нүүрсний овоолгууд үүсгэх, хэлбэржүүлэх, зам талбай тэгшлэх, ачилтын тавцан шинээр үүсгэх ажлуудыг гүйцэтгэнэ.

1.8.7. Захиалагчийн шийдвэрээр олборлосон нүүрсийг чанараар нь ангилан овоолго үүсгэх ба нүүрсний овоолгуудад чанарын холилт хийнэ.

1.8.8. Нүүрсний овоолгод бохирдолттой нүүрс буулгасан тохиолдолд шаардлагатай цэвэрлэгээг тогтмол хийнэ.

1.8.9. Нүүрсний хаягдал, бохирдлыг бууруулах, чанарыг дундажлах зорилгоор Захиалагчийн төлөвлөгөөний дагуу нүүрсний агуулахын талбайд цагт 700 тонноос багагүй нүүрс бутлах хүчин чадал бүхий автомат удирдлагын системтэй, хөдөлгөөнт бутлуурыг овоолго үүсгэгч болон бусад бүрдлийн хамт өөрийн зардлаар байгуулна

## **1.9. Байгаль орчин, усны бодлого, орчны хамгаалал, нөхөн сэргээлт:**

1.9.1. Гүйцэтгэгч нь байгаль орчин, усны бодлого хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу гэрээт олборлогчийн хүлээх үүргийг хуваарийн дагуу биелүүлж, биелэлтийг захиалагчид улирал бүр тайлагнана.

1.9.2. Шимт хөрсний овоолгыг захиалагчийн дотоод журам болон MNS 5916:2008 стандартын дагуу хуулах, овоолго үүсгэх, зүлэгжүүлэх хамгаалалт хийх ажлуудыг гүйцэтгэнэ. Шимт хөрсний 5.0 га талбай бүхий хэсэгт арчилгааны ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

1.9.3. Уурхайн үйл ажиллагаанаас үүссэн хий, хатуу, шингэн хог хаягдлыг Монгол улсын хууль, журам, стандарт болон захиалагчийн дотоод журмын дагуу төвлөрүүлэх, зайлуулах, аюултай хог хаягдлыг устгах буюу саармагжуулах, хог хаягдлын стандарт байгууламжийг барих, дахин боловсруулах үйлдвэрт хүргэх цогц арга хэмжээг тусгасан хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулан захиалагчаар хянуулан батлуулж гэрээт хугацаанд буюу тухайн жилдээ төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллана.

1.9.4. Үйл ажиллагааны явцад эвдэрсэн, доройтсон, бохирдсон газар болон хог хаягдлын түр цэгт техникийн нөхөн сэргээлт хийн бохирдлыг арилгаж, ажил дуусгавар болоход захиалагчид хүлээлгэж өгнө.

1.9.5. Ажлыг гүйцэтгэх үедээ нийтийн зам талбай, байгууламжид чулуу, шороо, барилгын материалын үлдэгдэл зэрэг хог хаягдал хаяхгүй цэвэр цэмцгэр байлгах, орчин тойрныг бохирдуулахгүй, хаягдсан хог материалыг бүрэн цэвэрлэж, орчны хэвийн нөхцөлийг тухайн ажлын өдөрт нь сэргээж, цэвэрлэж байна.

1.9.6. Ажил гүйцэтгэсэн хугацаанд уулын ажилд өртсөн, ашигласан бүхий л газар, талбайд нөхөн сэргээлт хийж захиалагчид хүлээлгэж өгнө.

1.9.7. Гүйцэтгэгч нь орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх багаж төхөөрөмжөөр ажил эхлэх үед тоноглогдсон байна. (Dust track)

1.9.8. Монгол улсад мөрдөгдөж байгаа Байгаль орчны багц хууль болон түүнийг дагаж гарсан дүрэм журмыг мөрдөх, MNS 5914:2008, MNS 5915:2008, MNS 5917:2008 стандартын дагуу эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, ургамалжуулалтын ажлыг хийж гүйцэтгэнэ.

1.9.9. Үндэсний хэмжээнд хэрэгжүүлж буй тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэн, тусгагдсан ажлуудыг дэмжиж ажиллана.

## **1.10. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй:**

1.10.1. Уулын ажлуудыг гүйцэтгэхдээ Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг чанд баримтлан ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал, эрүүл ахуйг бүрэн хариуцаж ажиллах бөгөөд холбогдох менежментийн системийг боловсруулан, захиалагчаар батлуулж, гэрээт хугацаанд үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллана.

1.10.2. Уурхайн технологийн ажлуудад зориулан аюулгүй ажиллагааны журам, горим боловсруулан ажил гүйцэтгэх хугацаанд Захиалагч талаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдүүлж ажиллах бөгөөд шаардлагатай эрсдэлийн үнэлгээг хийж ажиллана. Мөн үйл ажиллагаандаа OSHAS 18001 стандартыг нэвтрүүлж ажиллах бөгөөд шаардлагатай ажлууд дээр дутуу дүрэм журмыг боловсруулан захиалагчаар батлуулж, мөрдөж ажиллана.

1.10.3. Ажлын гүйцэтгэлийн явцад гарсан технологийн болон аливаа ажил үйлчилгээний доголдол гарсан тохиолдолд захиалагч талд мэдэгдсэний дагуу заасан

хугацаанд арга хэмжээ авч, үр дүнг захиалагч талд танилцуулж, зөвшөөрөл авсны дараагаар хэвийн үйл ажиллагааг эхэлнэ.

1.10.4. Захиалагч талын инженер техникийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчин, усны бодлогын /Цаашид ХАБЭА, БОУБ гэх/ ажилтнуудыг ажлын талбайд зохих журмын дагуу саадгүй нэвтрүүлэх бөгөөд тэдгээр ажилтны холбогдох дүрэм журамд нийцүүлэн тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

1.10.5. ХАБЭА, БОУБ-ны талаарх үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй, дамжуулахгүй, давхар гэрээлэхгүй.

1.10.6. ХАБЭА, БОУБ-той холбоотой аливаа зөрчил дутагдал гарсан болон цаашилбал хүний амь нас, эрүүл мэндэд хохирол үзүүлж болохуйц аюул, эрсдэлтэй нөхцөл аль нэг ажлын байр болон үйл ажиллагаанд үүссэн тохиолдолд талууд оролцож тэмдэглэл үйлдэн зогсооно.

1.10.7. Гүйцэтгэгч нь үүссэн аюул эрсдэлтэй ажлын байр болон нөхцлийг бүх ажлын байруудад арилгасны дараа үйл ажиллагааг захиалагчийн зөвшөөрлөөр эхлүүлнэ. Гүйцэтгэгч нь Захиалагчийн зөвшөөрөлгүй буюу засч залруулах арга хэмжээг хангалтгүй авсан үед үйл ажиллагаагаа дур мэдэн эхлүүлсэн эхний тохиолдолд ХАБЭА, БОУБ-н гүйцэтгэлийг дүгнэх түлхүүр үзүүлэлтийн ХАБ-ын хэсэгт харгалзах оноог бүхлээр нь; 2 дахь удаа уг зөрчлийг давтан гаргаж үйл ажиллагаагаа Захиалагчийн зөвшөөрөлгүй эхлүүлсэн тохиолдолд тухайн сард ХАБЭА, БОУБ хэсэгт харгалзах бүхлээр нь шууд хасах; 3 дахь удаа уг зөрчлийг давтан гаргаж үйл ажиллагаагаа Захиалагчийн зөвшөөрөлгүй эхлүүлсэн тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

1.10.8. ХАБЭА, БОУБ-ны гүйцэтгэлийг жил, улирал болон сараар дүгнэх, уг дүгнэлтийг сар бүрийн төлбөртэй хэрхэн уялдуулж тооцоолох Гүйцэтгэлийн Түлхүүр Үзүүлэлтийг гэрээнд нарийвчлан тусгана.

### **1.11. Уулын ажлын гүйцэтгэх үнэлгээ**

1.11.1. Уурхайн бүсэд хамаарах (хавсралт зураг №1-д тусгагдсан) уулын цулын ажлыг гүйцэтгэх нэгж үнэлгээг (шимт хөрс хуулах, тэсэлгээгүй уулын цул, нүүрс олборлолт, 1км хөрс, нүүрс тээвэрлэх) тооцож төгрөг/м<sup>3</sup>-ээр ирүүлнэ.

1.11.2. Захиалагч нь уулын ажлын гүйцэтгэлийн төлбөрийг гүйцэтгэгч талд төгрөгөөр төлнө.

1.11.3. Захиалагчийн хэрэгжүүлж буй мөчлөг урсгалт конвейерийн систем ашиглалтад орсон үед талууд тохиролцож ажил гүйцэтгэх үнэлгээг бууруулна.

### **1.12. Ажлын даалгаврын хавсралт**

1.12.1. Хавсралт зургууд:

- Зураг№1. Уурхайн төлөвлөгөөний зураг

1.12.2. Хавсралт хүснэгтүүд:

- Хүснэгт №1. Хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлын хэмжээ
- Хүснэгт №2. Уурхайн үндсэн техник, тоног төхөөрөмжүүдийн ажлын үзүүлэлт
- Хүснэгт №3. Уурхайд ажиллах техник, тоног төхөөрөмжүүдийн жагсаалт



## 2. ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

### 2.1. Ерөнхий:

2.1.1. Гүйцэтгэгч нь 3-аас доошгүй жил уул уурхайн салбарт олборлолтын ажил, үйлчилгээ гүйцэтгэж байсан туршлагатай байх.

2.1.2. Гүйцэтгэгчийн баг бүрэлдэхүүн нь (Уурхайн уулын ажлыг гүйцэтгэх ажилтнууд нь) ажил үүргээ аюул, осолгүй, технологийн горимын дагуу хэвийн явуулах машин, тоног төхөөрөмж, ажлын багаж, төхөөрөмж хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр бүрэн хангагдсан байна.

2.1.3. Цаг ашиглалт болон техникийн бэлэн байдлыг 85-аас доошгүй хувьтай байлгана.

2.1.4. Гүйцэтгэгч нь олборлож буй нийт нүүрсний тодорхой хэсэгт олборлолтын үеийн хаягдал, бохирдлыг өнөөгийн түвшингөөс бууруулах дэвшилтэт технологиор ангилан олборлох үүрэг хүлээнэ.

2.1.5. Гэрээний хугацаанд ХАБЭА, БОУБ-н холбогдолтой хууль, дүрэм, журам зөрчигдсөнөөс үүдэлтэй бүтээлийн алдагдал, цаг хугацаатай холбоотой аливаа хохирлыг Гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.

2.1.6. ХАБЭА, БО-ны тухай хуулийн дагуу Гүйцэтгэгчийн бүх ажилтан ажиллагсад өөрийн компанийн аюулгүй ажиллагааны сургалт, зааварчилгаанд ажил эхлэх үед бүрэн хамрагдсан байна.

2.1.7. Шалгарсан оролцогч нь ажил эхлэхэд өөрийн бүх тээврийн хэрэгслүүд болон түүнийг ажиллуулах операторуудыг тээврийн хэрэгслийн болон жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамруулсан байна.

2.1.8. Гэрээ байгуулснаас хойш 30 хоногийн дотор тендерийн ажлыг өгөгдсөн хуваарийн дагуу саадгүй хийж гүйцэтгэхэд шаардлагатай дэд бүтэц, барилга байгууламж, ахуй хангамжтай холбоотой асуудлуудыг бүрэн шийдвэрлэсэн байна.

2.1.9. Шалгарсан оролцогч нь шатахууны хангалт, нөөцлөлтийг Захиалагчийн үйл ажиллагааг тасалдуулахгүй байхаар хангаж ажиллах бөгөөд шатахуун нийлүүлэгч компанитай хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллана.

2.1.10. Гэрээ байгуулснаас хойш 30 хоногийн дотор хавсралтад заасан уулын ажлыг хийж гүйцэтгэх хүчин чадалтай техник, тоног төхөөрөмжийг уурхайд бэлэн байлгаж ажлыг эхлүүлнэ. Ажил эхлээгүй тохиолдолд Захиалагчаас баталсан төлөвлөгөөний дагуу хоногт гүйцэтгэх ёстой байсан ажлын үнийн дүнгийн 0.01 хувийн төлбөрийг хоног тутамд төлнө.

### 2.2. Хүн хүч:

2.2.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай дараах мэргэжлийн баг, ажиллах хүний нөөцөөр ажил эхлэх үед бүрэн хангагдсан байна.

#### Хүснэгт №1 Ажиллах хүний нөөцийн мэдээлэл

№	Мэргэжил	Тоо
1	Төлөвлөлтийн инженер	2
2	Ашиглалтын инженер	2
3	Маркшейдер инженер	4
4	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн	4
5	Байгаль орчны мэргэжилтэн	2
6	Ээлжийн мастер	4
7	Нүүрсний мастер	4
8	Геотехник хариуцсан инженер	2

9	Геологич инженер	2
10	Засварын механик	4

2.2.2. Шалгарсан оролцогч нь ажил эхлэхэд осол аваарын үед эмнэлгийн тусламж үзүүлэх зориулалтын түргэн тусламжийн машин, эмч, эмнэлгийн ажилтан, яаралтай тусламжийн нэгжтэй байна.

2.2.3. Оролцогч нь ажил гүйцэтгэх хугацаанд ХАБЭА, мэргэжлийн болон бусад үйл ажиллагаанд шаардлагатай сургалтыг бүрэн хариуцах бөгөөд сургалтын бүртгэл тайланг Захиалагчийн сургалт хариуцсан нэгжид хүргүүлж байна.

### 2.3. Уулын ажилд ашиглагдах Техник хэрэгсэл, машин механизм:

Гүйцэтгэгч нь хүснэгт №3 болон хавсралт зургуудад заасан уулын ажлыг гүйцэтгэх шаардлагатай техник хэрэгсэл, машин механизмаар бүрэн хангагдсан байна.

Сард 1.0-2.0 сая м<sup>3</sup> уулын цул гүйцэтгэх, жилд 15.0-24.0 сая м<sup>3</sup> уулын цулын ажил гүйцэтгэх техник, тоног төхөөрөмжийн хослол бэлэн байлгаж ажиллана.

*Хүснэгт №2 Техник, тоног төхөөрөмжид тавигдах шаардлага*

<b>А. Ухаж ачих, тээвэрлэх техникүүд</b>	
2023-2024 он	2025-2026 он
<p>Хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажил гүйцэтгэх экскаваторууд нь урвуу утгууртай байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• <b>12 м<sup>3</sup>-с</b> багагүй утгуурын багтаамжтай экскаватор <b>3-аас</b> багагүй, <b>5-8 м<sup>3</sup></b> утгуурын багтаамжтай экскаватор <b>2-оос</b> багагүй байна.</li> <li>• Эдгээр экскаваторуудтай хослож ажиллах автосамосвалуудын нийлбэр даац нь <b>5,000</b> тонноос багагүй байна. Үүнээс <b>90</b> тонноос багагүй даацтай автосамосвалуудын нийлбэр даац 2600 тонноос багагүй, 50-90 тоннын даацтай автосамосвалуудын нийлбэр даац 2400 тонноос багагүй байна.</li> </ul> <p>Нийт автосамосвалуудын нийлбэр даацын 30 хүртэлх хувьд давхар тэнхлэгтэй автосамосвалууд байж болно.</p>	
<b>В. Туслах техникүүд</b>	
2023-2024 он	2025-2026 он
<ul style="list-style-type: none"> <li>• <b>1-с</b> доошгүй 2-5 м<sup>3</sup> шанаганы багтаамжтай экскаваторыг уурхайд ажиллуулна. (Нүүрсний ялгалт, цэвэрлэгээний ажилд ашиглана.)</li> <li>• 8.0 м<sup>3</sup>-с багагүй хутганы багтаамжтай 4-аас доошгүй бульдозеруудыг ажиллуулна.</li> <li>• 4 м-с багагүй хутганы өргөнтэй 3-с доошгүй автогрейдеруудыг ажиллуулна.</li> <li>• 3-с доошгүй 20-60 тонны даацтай усалгааны машинуудыг ажиллуулна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• <b>1-с</b> доошгүй 2-4 м<sup>3</sup> шанаганы багтаамжтай экскаваторыг уурхайд ажиллуулна. (Нүүрсний ялгалт, цэвэрлэгээний ажилд ашиглах)</li> <li>• 8.0 м<sup>3</sup>-с багагүй хутганы багтаамжтай 6-аас доошгүй бульдозеруудыг ажиллуулна.</li> <li>• 4 м-с багагүй хутганы өргөнтэй 5-с доошгүй автогрейдеруудыг ажиллуулна.</li> <li>• 5-с доошгүй 20-60 тонны даацтай усалгааны машинуудыг ажиллуулна.</li> </ul>
<p>Эдгээр техникүүдийг Захиалагчаас төлөвлөсөн болон шаардсан хугацаанд ажиллуулаагүй тохиолдолд гарсан хохирлыг төлүүлнэ.</p>	

### **С. Бусад туслах техникүүд**

*Доорх техникүүд нь түрээсийн болон бусад гэрээтэй байж болох бөгөөд ажил эхлүүлэх болон ажил гүйцэтгэх үед уурхайд захиалагчаас шаардсан тоо хэмжээгээр бэлэн байлгана.*

- Гэрэлтүүлэгч цамхаг
- Тосолгооны машин
- Хог, хаягдлыг тээвэрлэх машин
- Автокран
- Дугуй өргөгч
- Түлшний машин
- Усны насос
- Галын машин
- Түргэн тусламжийн машин

2.3.1. Шаардлагатай тохиолдолд Захиалагчаас гаргасан төлөвлөгөөний дагуу уурхайд ажиллах техник, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх болон бууруулах боломжтой байна.

2.3.2. Уурхайн төлөвлөсөн уулын ажлын хэмжээ, шаардлагатай хүчин чадалд хүрэхгүй бол Гүйцэтгэгч нь Захиалагчийн заасан хугацаа, техникийн тодорхойлолтын дагуу техник, тоног төхөөрөмжийг Цанхийн баруун уурхайд бэлэн байлгана.

2.3.3. Уурхайд ажиллах тоног төхөөрөмжүүдийн тоо, бүтээл, ашиглалтад орсон огноо, техникийн бэлэн байдал зэрэг бусад нарийвчилсан үзүүлэлтүүдийг харуулсан дэлгэрэнгүй жагсаалтыг ирүүлнэ. Жагсаалтад үзүүлсэн тоног төхөөрөмжүүдийн холбогдох бичиг баримтын хуулбарыг ирүүлнэ. /хүснэгт №4-ийн дагуу/

#### **2.4. Дэд бүтэц, барилга, байгууламж:**

Уулын ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардлагатай дараах барилга, байгууламжуудыг ажил эхлэх үед ашиглалтад оруулж, шийдвэрлэж ажиллана.

Үүнд:

- Ариун цэврийн шаардлага хангасан кемп буюу ажилчдын сууц, амрах байр, мөн хоол хүнс зориулалтын дагуу хадгалах агуулах
- Стандартын дагуу баригдсан ахуйн хог хаягдлын цэг
- Эрчим хүчний эх үүсвэр (нөөцийн генераторууд)
- Засварын байр, түүнийг дагалдах тоноглол, байгууламж
- Оффисын байр, сургалтын танхим
- Стандартын ашигласан тос төвлөрүүлэх байгууламж
- Хог хаягдлыг шатаах зориулалтын төхөөрөмж бүхий хоргүйжүүлэх талбай
- Бохирдсон хөрсийг төвлөрүүлэн биологийн аргаар саармагжуулах талбай

### 3. БУСАД ШААРДЛАГА

3.1. Уулын ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардлагатай аливаа тусгай зөвшөөрөл авах, сум орон нутагтай гэрээ байгуулах, орон нутгийн засаг захиргаанаас тушаал шийдвэр гаргуулах, газар ус болон түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах зөвшөөрөл авах зэрэг асуудлыг Гүйцэтгэгч тал өөрөө хариуцах бөгөөд ийнхүү хийгээгүйгээс гарсан аливаа хохирлыг Захиалагч тал болон бусад талууд хариуцахгүй.

3.2. Шаардлагатай тохиолдолд Захиалагчийн гаргасан төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэх ажлын хэмжээг нэмэгдүүлж

3.3. Төлөвлөгөөний дагуу тухайн сард гүйцэтгэх уулын цулын 0.5 хувьд ногдох хэмжээний бүтээлийн бус инженерийн ажлыг хийж гүйцэтгэнэ. Тухайн сард хийгдээгүй инженерийн ажлыг хуримтлагдсан дүнгээр жилийн хэмжээнд тооцон хийж болно. Бүтээлийн бус инженерийн ажил гэдэг нь Гүйцэтгэгчийн гүйцэтгэх ажилд буюу 1 дүгээр зүйлд зааснаас бусад Захиалагчийн төлөвлөгөөт ажлыг хэлнэ.

3.4. Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажил /KPI/-ыг дараах байдлаар үнэлж оноо өгнө.

- Гэрээний үүргийн хэрэгжилт (10 оноо)
- Үйлдвэрлэл, технологи (50 оноо)
- Нүүрсний чанар (20 оноо)
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (10 оноо).
- Байгаль орчин (10 оноо).

3.5. Гүйцэтгэгчийн тухайн сард гүйцэтгэсэн ажлын KPI оноо 90 онооноос багаар үнэлэгдсэн тохиолдолд тухайн сарын төлөвлөгөөт ажлын мөнгөн дүнгээс дараах байдлаар харгалзах хувиар Гүйцэтгэгчид төлөх нийт төлбөрөөс хасаж тооцно.

- 89.9-85 оноогоор үнэлэгдсэн бол тухайн сард гүйцэтгэх төлөвлөгөөт ажлын мөнгөн дүнгийн 0.01%-иар,
- 84.9-80 оноогоор үнэлэгдсэн бол тухайн сард гүйцэтгэх төлөвлөгөөт ажлын мөнгөн дүнгийн 0.02%-иар,
- 79.9-75 оноогоор үнэлэгдсэн бол тухайн сард гүйцэтгэх төлөвлөгөөт ажлын мөнгөн дүнгийн 0.03%-иар,
- 74.9 буюу түүнээс доош оноогоор үнэлэгдсэн бол тухайн сард гүйцэтгэх төлөвлөгөөт ажлын мөнгөн дүнгийн 0.05%-иар тус тус тооцно.

3.6. Гэрээний хугацаанд 3 удаа /сар/ KPI онооны нийлбэр 70 хувиас доош орсон тохиолдолд Захиалагчийн санаачилгаар гэрээг цуцалж болно. Дэлгэрэнгүй задаргааг гэрээнд заана.

3.7. Гүйцэтгэгч нь Төслийн удирдлагын багийн гүйцэтгэлийн хурлаас өгсөн хугацаат үүрэг даалгаврыг заасан хугацаанд хэрэгжүүлнэ. Хэрэгжүүлээгүй тохиолдолд KPI онооноос хасна.

3.8. Гүйцэтгэгч нь Төслийн удирдлагын багийн гүйцэтгэл дүгнэх хуралд ажлын тайланг танилцуулах бөгөөд хийж гүйцэтгэсэн ажлын хэмжээ, ажлын нэгж өртөг, түлш зарцуулалт, тоног төхөөрөмжүүдийн гүйцэтгэлүүдийг холбогдох нотлох баримтуудын хамт тайланд багтаасан байх ба дараа сарын 03-ны өдрөөс өмнө Захиалагчид ирүүлсэн байна. Тайлангийн чанар, бэлтгэсэн байдал, мэдээлэл зэрэг нь Захиалагчийн шаардлагад нийцээгүй тохиолдолд тайланг буцааж, гүйцэтгэл дүгнэх хурлыг хойшлуулж болно.

3.9. Захиалагч гэрээний дүгнэлт танилцуулах, Гүйцэтгэгчийн тайлантай танилцах хурлыг төслийн удирдлагын багийн дарга дараа сарын 10-ны дотор товлон зарлаж хуралдуулна.

3.10. Гүйцэтгэгч нь ажлын даалгаварт заасан техник хэрэгсэл, машин механизм болон дэд бүтцийн барилга байгууламжийг заасан хэмжээ, үзүүлэлтийн дагуу уурхайд бэлэн байлгах бөгөөд холбогдох нотлох баримтуудыг сар бүрийн 03-ны өдрөөс өмнө Захиалагчид хүргүүлнэ.

3.11. Гүйцэтгэгч нь 14-өөс багагүй хоног ажил гүйцэтгэхэд шаардлагатай түлш, сэлбэг хэрэгслийн нөөцтэй байх бөгөөд холбогдох нотлох баримтуудыг сар бүрийн 15-ны өдөр Захиалагчид хүргүүлнэ.

3.12. Гүйцэтгэгч нь нийт ажилчдын 5-аас доошгүй хувийг орон нутгийн ажилчдаас бүрдүүлнэ.

3.13. Захиалагч нь Цанхийн баруун уурхайн хөрс хуулалтад авто-конвейерийн хосолсон тээвэртэй мөчлөг-урсгал технологийн иж бүрдэл нэвтрүүлэх төслийн хүрээнд Захиалагчийн үйл ажиллагааг Гүйцэтгэгч дэмжин ажиллана.

3.14. Цанхийн зүүн уурхай болон бусад хэсгийн гэрээт олборлогч компанийн техникуудийг Цанхийн баруун уурхайд шилжүүлэн оруулах, ажиллуулах тохиолдолд заавал захиалагчаас бичгээр зөвшөөрөл авна.

3.15. Захиалагч нь 7-оос доошгүй хоногийн өмнө урьдчилан мэдэгдсэний дүнд уулын ажлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд уурхайд сул зогсолт хийлгэх эрхтэй. Үүнтэй холбоотой захиалагч талаас ямарваа нэг төлбөрийн хариуцлага хүлээхгүй.

3.16. Цанхийн баруун уурхайд ажиллаж буй техник, тоног төхөөрөмжүүд ажлын талбайд багталцахгүй байх, бусад асуудлаас шалтгаалан техникүүд ажиллаагүй тохиолдолд захиалагч тал хариуцахгүй. Үүнтэй холбоотой захиалагч талаас ямарваа нэг төлбөрийн хариуцлага хүлээхгүй.

3.17. Давагдашгүй хүчин зүйл (УИХ, Засгийн газрын шийдвэр, Хууль тогтоомжийн өөрчлөлт, ажил хаялт эдийн засгийн хямрал, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, гал түймэр, үер усны гамшиг болон бусад байгалийн гамшигт үзэгдэл, гадаад худалдааны хорио цээр болон экспорт, импортын хориг, терроризм, бусад багцын ХАБ-ын зөрчил)-ийн улмаас биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд захиалагч тал хариуцахгүй. Үүнтэй холбоотой захиалагч талаас ямарваа нэг төлбөрийн хариуцлага хүлээхгүй.

#### 4. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУВААРЬ

Хүснэгт №3 Хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлын хэмжээ

Сар	Хөрс хуулалт, м3	Нүүрс олборлолт, тн	Уулын цул, м3	Инженерийн ажил, м3
2023 (4-9-р сар)	6,562,423.8	1,335,000.0	7,515,995.3	37,580.0
2024	10,900,000.0	2,240,000.0	12,500,000.0	62,500.0
2025	20,914,285.7	4,320,000.0	24,000,000.0	120,000.0
2026 (1-3-р сар)	5,228,571.4	1,080,000.0	6,000,000.0	30,000.0
<b>Дүн</b>	<b>43,605,281.0</b>	<b>8,975,000.0</b>	<b>50,015,995.3</b>	<b>250,080.0</b>

Уулын ажлын хэмжээг тухайн жил, сарын онцлогт нь тохируулж, нүүрсний эрэлт нийлүүлэлтээс хамааран нэмэх, хасах зэргээр хэлбэлзэнэ. Иймд тухайн жилийн ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, сарын төлөвлөгөө зэргээр тохируулж болно.

Захиалагч нь урьдчилан мэдэгдсэний дүнд уулын ажлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд уурхайд сул зогсолт хийлгэх эрхтэй. Үүнтэй холбоотой захиалагч талаас ямарваа нэг төлбөрийн хариуцлага хүлээхгүй.

Уурхайд ажиллах тоног төхөөрөмжүүдийн жагсаалт

Хүснэгт №4

Д	Тоног төхөөрөмжийн нэр			Хүчин чадал багтаамж		Өмчлөлийн хэлбэр	Ашиглалтын хугацаа			Түлш зарцуулалт			Техникийн бэлэн байдал %	Тайлбар
	Төрөл	Загвар	Үйлдвэрлэсэн улс	Нэгж	Хэмжээ		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад өгсөн он	Ашиглалтын хугацаа	Хэмжих нэгж (л/мот.цаг)	Нийт ажилласан мот.цаг	Нийт зарцуулсан түлшний хэмжээ		
	Экскаватор													
	Автосамосвал													
	Ачигч													
	Бульдозер													
	Грейдер													
	.....													

Жич: Тоног төхөөрөмжүүдийн цаг ашиглалт болон техникийн бэлэн байдлыг 85-аас доошгүй хувьтай байлгана. Ирүүлсэн жагсаалтын дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн техникийн комисс тоног төхөөрөмжүүдийн бэлэн байдлыг шалгана.

